



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 476


Улаанбаатар хот

“Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн
үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 311 дүгээр тогтоолын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Компанийн оноосон нэрээс “ҮЦК” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК /Б.Ариунтуул/-д үүрэг болгосугай.
3. “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн болон арилжааны үйл ажиллагаатай холбоотой холбогдох баримтыг өөрийн архивт хүлээн авахыг “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК /О.Эрдэнэгэрэл/, “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/, “Монголын хөрөнгийн бирж” ХХК /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.
4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800001056